

БАТЛАВ  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА  
*М.Ш.Ч.* Ч. МӨНХТУЯА

БАТЛАВ  
УЛСЫН ГУРАВ ДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН  
ЗАХИРАЛ  
*Ч.Т.О.* Ц. ТӨМӨР-ОЧИР

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2023 оны 07 дугаар сарын 05

№ 10/23

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга бөгөөд Улсын ерөнхий байцаагч П.Ганболд /цаашид "А тал" гэх/, нөгөө талаас Улсын гуравдугаар төв эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга С.Наранцэцэг /цаашид "Б тал" гэх/, нар эрүүл мэндийн гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нисгэгч болон нислэгийн удирдагч наарт эрүүл мэндийн гэрчилгээ олгоход шаардлагатай үзлэг шалгалт хийх тусlamж үйлчилгээг үзүүлэх зорилгоор дараах нөхцөлөөр харилцан тохиролцож знэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Улсын гуравдугаар төв эмнэлэг нь Иргэний нисэхийн ерөнхий газар /цаашид "ИНЕГ" гэх-/ын нэрийн өмнөөс Чикагогийн конвенцын Хавсралт 1-д заасан эрүүл мэндийн шаардлага, Монгол Улсын Иргэний нисэхийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 187 дугаар тушаалын 12 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-67 "Эрүүл мэндийн стандарт болон гэрчилгээ" дүрмийн дагуу гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нисгэгч болон нислэгийн удирдагч наарт эрүүл мэндийн гэрчилгээ олгоход шаардлагатай үзлэг шалгалт хийх тусlamж үйлчилгээг үзүүлэхтэй холбогдуулан талуудын харилцан эрх эдлэх, үүрэг хүлээх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гэрээнд заасан нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

1.2.1. Энэхүү гэрээний дагуу эмнэлгийн үзлэгийг гүйцэтгэх нисэхийн анагаах ухааны сургалтанд хамрагдсан эмчийг "эрүүл мэндийн шалгагч" гэнэ.

1.2.2. ИНД-67 "Эрүүл мэндийн стандарт болон гэрчилгээ"-ний дагуу эрүүл мэндийн гэрчилгээ авахаар хүсэлт гаргагчийг "өргөдөл гаргагч" гэнэ.

1.3. Эрүүл мэндийн шалгагч /цаашид ЭМШ гэх/ нь энэхүү гэрээгээр тохирсон үүрэг, хариуцлагыг ИНЕГ-ын өмнө биечлэн хариуцна.

1.4. ЭМШ нь Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны /цаашид "НААХЗА" гэх/ Үнэмлэх гэрчилгээжүүлэлтийн хэлтэст /цаашид "ҮГХ" гэх/ үйл ажиллагааны дагуу харьяалагдана.

1.5. Энэхүү гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн ЭМШ -ийн ажлын хөлсийг өргөдөл гаргагч хариуцна.

1.6. Гэрээнд заасан ажил үүргийн гүйцэтгэлийг сар бүрийн 25-ны өдөр НААХЗА-ны ҮГХ-ийн даргад ирүүлнэ.

Хоёр. Улсын гуравдугаар төв эмнэлгийн үүрэг, эрх

2.1. Улсын гуравдугаар төв эмнэлэг нь эрүүл мэндийн шалгагчаар ажиллах эмчийг сонгож мэргэжлийн сургалтад хамруулан бэлтгэж ЭМШ-аар ажиллуулах хүсэлтээ ИНЕГ-т ирүүлсэн байна.

2.2. Сонгогдсон эмч нь ИНД-67-д заасны дагуу шаардлага хангаж байгаагаа ИНЕГ-ын даргад нотлон харуулна.

2.3. ИНЕГ-ын нэрийн өмнөөс өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ИНД-67-д заасны дагуу нисгэгч, нислэгийн удирдагч наарт үзлэг шалгалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

БАТЛАВ  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА *М.Мөнхзул* Ч. МӨНХТУЯА

БАТЛАВ  
“СӨҮЛ СЕНИОРС” ТОВЕР ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
*М.Мөнхзул* М.МӨНХЗУЛ

### ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2023 оны 05 дугаар сарын 05

№ 43/3

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга бөгөөд Улсын ерөнхий байцаагч П.Ганболд /цаашид “А тал” гэх/, нөгөө талаас “Сөүл Сениорс Товер” ХХК-ийн Улаанбаатар Сонгдо Эмнэлгийн Эмнэлзүйн захирал Н.Оюунбилэг /цаашид “Б тал” гэх/, нар эрүүл мэндийн гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нисгэгч болон нислэгийн удирдагч наарт эрүүл мэндийн гэрчилгээ олгоход шаардлагатай үзлэг шалгалт хийх тусламж үйлчилгээг үзүүлэх зорилгоор дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

#### Нэг. Ерөнхий зүйл

1.1. “Сөүл Сениорс Товер” ХХК нь Иргэний нисэхийн ерөнхий газар /цаашид “ИНЕГ” гэх/ нийн өмнөөс Чикагогийн конвенцын Хавсралт 1-д заасан эрүүл мэндийн шаардлага, Монгол Улсын Иргэний нисэхийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 187 дугаар тушаалын 12 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-67 “Эрүүл мэндийн стандарт болон гэрчилгээ” дүрмийн дагуу гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нисгэгч болон нислэгийн удирдагч наарт эрүүл мэндийн гэрчилгээ олгоход шаардлагатай үзлэг шалгалт хийх тусламж үйлчилгээг үзүүлэхтэй холбогдуулан талуудын харилцан эрх здлэх, үүрэг хүлээх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гэрээнд заасан нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

1.2.1. Энэхүү гэрээний дагуу эмнэлгийн үзлэгийг гүйцэтгэх нисэхийн анагаах ухааны сургалтанд хамрагдсан эмчийг “эрүүл мэндийн шалгагч” гэнэ.

1.2.2. ИНД-67 “Эрүүл мэндийн стандарт болон гэрчилгээ”-ний дагуу эрүүл мэндийн гэрчилгээ авахаар хүсэлт гаргагчийг “өргөдөл гаргагч” гэнэ.

1.3. Эрүүл мэндийн шалгагч /цаашид ЭМШ гэх/ нь энэхүү гэрээгээр тохирсон үүрэг, хариуцлагыг ИНЕГ-ын өмнө биечлэн хариуцна.

1.4. ЭМШ нь Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны /цаашид “НААХЗА” гэх/ Үнэмлэх гэрчилгээжүүлэлтийн хэлтэст /цаашид “ҮГХ” гэх/ үйл ажиллагааны дагуу харьяалагдана.

1.5. Энэхүү гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн ЭМШ -ийн ажлын хөлсийг өргөдөл гаргагч хариуцна.

1.6. Гэрээнд заасан ажил үүргийн гүйцэтгэлийг сар бүрийн 25-ны өдөр НААХЗА-ны ҮГХ-ийн даргад ирүүлнэ.

#### Хоёр. “СӨҮЛ СЕНИОРС ТОВЕР” ХХК –ийн үүрэг, эрх

2.1. “Сөүл Сениорс Товер” ХХК нь ЭМШ-аар ажиллах эмчийг сонгож мэргэжлийн сургалтад хамруулан бэлтгэж ЭМШ-аар ажиллуулах хүсэлтээ ИНЕГ-т ирүүлсэн байна.

2.2. Сонгогдсон эмч нь ИНД-67-д заасны дагуу шаардлага хангаж байгаагаа ИНЕГ-ын даргад нотлон харуулна.

2.3. ИНЕГ-ын нэрийн өмнөөс өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ИНД-67-д заасны дагуу нисгэгч, нислэгийн удирдагч наарт үзлэг шалгалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.